



12 УЛС ОРНУУДЫН БООЦОТ ТОГЛООМЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Д.Дашням, Э.Элбэгзаяа, Б.Гал, Д.Хулан, Ц.Батнавч

ХУРААНГУЙ:

Энэхүү судалгаагаар бооцот тоглоомын хууль эрх зүйн орчны олон улсын зохицуулалтыг харьцуулан судалж, Монгол Улсад тохирох зохицуулалтын боломжийг тодорхойлохыг зорив. Дэлхий даяар цахим мөрийтэй тоглоомын зах зээл эрчимтэй тэлж, 2030 он гэхэд 182 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна. Монгол Улсад ийм тоглоом өргөн дэлгэрч, их хэмжээний мөнгө гадагш урсаж байгаа тул хяналт, зохицуулалт нэн шаардлагатай байна.

Судалгаагаар 231 улсын 56.7% нь цахим мөрийтэй тоглоомыг зохицуулсан, 26.4% нь хориглосон, үлдсэн нь тодорхойгүй зохицуулалттай байна. Европ, Америк, Африк, Ойрх Дорнодын орнуудын ихэнх нь зохицуулалттай байдаг бол Ази–Номхон далайн бүсийн орнуудын дийлэнх нь хориглодог.

Их Британи, Сингапур, Герман зэрэг орнууд хатуу хяналт, татвар, хариуцлагын тогтолцоотой байдлаар бооцот тоглоомыг зөвшөөрдөг бол Өмнөд Солонгос, Япон зэрэг орон бүрэн хориглодог байна.

Монгол Улсад цахим бооцот тоглоомын үйл ажиллагааг хуульчилж, зөвшөөрлийн тогтолцоо, татвар, хяналт болон хэрэглэгчийн эрхийг хамгаалах бодлогыг нэгдсэн байдлаар хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэв.

Түлхүүр үгс: Бооцот тоглоом, цахим мөрийтэй тоглоом, хууль эрх зүйн зохицуулалт

JEL ангилал: L83, K23

- ¹ СЗХ, ЗЗСХГ, Ахлах референт, dashnyam_d@frc.mn
- ² СЗХ, ЗЗСХГ, Ахлах мэргэжилтэн, elbegzaya@frc.mn
- ³ СЗХ, ЗЗСХГ, Мэргэжилтэн, gal@frc.mn
- ⁴ СЗХ, ЗЗСХГ, Мэргэжилтэн, khulan@frc.mn
- ⁵ СЗХ, ЗЗСХГ, Мэргэжилтэн, batnavch@frc.mn

АГУУЛГА >>>

I.	УДИРТГАЛ	372
II.	БООЦООТ ТОГЛООМЫН ТУХАЙ	372
III.	ОРОЛЦОГЧ ТАЛУУД БА ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭ	373
IV.	УЛС ОРНУУДЫН ХУУЛЬ, ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	379
	ДҮГНЭЛТ, САНАЛ	384
	АШИГЛАСАН МАТЕРИАЛ	386

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Оролцогч талууд ба үүрэг	377
Хүснэгт 2.	Үйл ажиллагааг хуулиар бүрэн болон хэсэгчлэн зөвшөөрсөн улс орнуудын зохицуулалт	379
Хүснэгт 3.	Бооцоот тоглоомын үйл ажиллагааг хориглосон улсууд	381
Зураг 1.	Цахим бооцоот тоглоом (online)-ын зохицуулалтын ерөнхий байдал, улс орноор	374
Зураг 2.	Уламжлалт мөрийтэй тоглоом (offline)-ын зохицуулалтын ерөнхий байдал, улс орноор	374
Зураг 3.	Латин Америкийн бүс нутгийн мөрийтэй тоглоомын зохицуулалт	375
Зураг 4.	Европ, Ойрх Дорнод, Африк бүс нутгийн мөрийтэй тоглоомын зохицуулалт	375
Зураг 5.	Ази-Номхон далайн бүс нутгийн мөрийтэй тоглоомын зохицуулалт	376

I. УДИРТГАЛ

Энэхүү судалгааны ажлын зорилго нь бооцоот тоглоомын хууль эрх зүйн орчны олон улсын хэв маяг, зохицуулалтын онцлогийг харьцуулж, Монгол Улсын нөхцөлд тохирохуйц зохицуулалтын арга хэмжээг тодорхойлох явдал юм. Өнөө үед цахим технологийн дэвшил, интернэтийн өргөн хэрэглээний улмаас цахим бооцоот тоглоом дэлхийн олон орнуудад хурдтайгаар хөгжиж, хууль эрх зүйн шинэ тутам зохицуулалтыг шаардаж байна.

Бооцоот тоглоом гэдэг нь спортын арга хэмжээний үр дүнд мөрий тавих үйл ажиллагааг хэлдэг мөрийтэй тоглоомын нэг хэлбэр юм. Мөрий тавигддаг арга хэмжээнүүд нь уламжлалт морин уралдаан, сагсан бөмбөг гм спортын бүх төрөл байж болно. Бооцоог ихэвчлэн бооцооны газар буюу «спортын бооцооны газар» (sportsbook) гэж нэрлэгддэг байгууллагуудаар дамжуулан тавьдаг. Эдгээр нь уламжлалт (казино) болон онлайнгаар үйл ажиллагаа явуулдаг байна.

Дэлхийн томоохон мөрийтэй тоглоомын компаниудын дунд тэргүүлэгч нь Их Британид төвтэй bet365 бөгөөд түүнчлэн

АНУ–д төвтэй Wynn Resorts зэрэг компаниуд багтдаг. 2022 онд эдгээр компани тус бүр гурван тэрбум ам.доллараас дээш үнэлгээтэй байсан бөгөөд bet365 нь дөрвөн тэрбум ам.доллараас давсан байна (www.statista.org, n.d.).

Бооцоот тоглоомын зохицуулалт нь зөвхөн эдийн засгийн өсөлт, татварын орлого гаргах талаасаа бус, мөн хэрэглэгчдийн эрхийг хамгаалах, гэмт хэргийн үр нөлөөллийг багасгах, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зэрэг зорилгоор тодорхой зохицуулалтуудыг шаарддаг байна.

Энэхүү судалгаагаар улс орнуудын цахим бооцоот тоглоомын зах зээлийн зохицуулалтын онцлог, ялгаа болон ижил төстэй байдлыг харьцуулан шинжилж, Монгол Улсын одоогийн нөхцөл байдалд тохирохуйц зохицуулалтын боломжийг санал болгоход оршино.

Судалгааны ажил нь бооцоот тоглоомын тухай, оролцогч талууд ба үүрэг, улс орнуудын хууль, эрх зүйн зохицуулалт, дүгнэлт, санал гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

II. БООЦООТ ТОГЛООМЫН ТУХАЙ

Бооцоот тоглоомыг цахим бооцоот/мөрийтэй тоглоом (Online gambling), уламжлалт бооцоот/мөрийтэй тоглоом (offline gambling) гэж ерөнхийд нь ангилдаг байна.

Гол ойлголтууд, чухал нэр томъёонуудыг Их Британи улсын Мөрийтэй тоглоомын тухай хууль (The Gambling Act 2005)–д дараах байдлаар тайлбарласан байна.

1. Тоглоом (Gaming) – Шагналын төлөө азын тоглоом тоглохыг хэлнэ. Азын тоглоомд цэвэр аз туршсан тоглоом төдийгүй ур чадварын элемент багтсан тоглоомууд ч орж болно. Үүнд: покер, рулет гм тоглоом орно. Харин спортын үйл ажиллагаа мөрийтэй тоглоомын ангилалд орохгүй.
2. Бооцоо (betting) – Ямар нэгэн үйл явдал, тэмцээн эсвэл тодорхойгүй үр дүн дээр бооцоо тавих. Үүнд спортын бооцоо, морины уралдааны бооцоо, бусад бооцоот тоглоомууд хамаарна.
3. Сугалаа (lottery) – Оролцогчид төлбөр төлж оролцох шаардлагатай шагналыг зөвхөн азаар хуваарилдаг. Шагнал нь мөнгө, эд зүйлс эсвэл үйлчилгээ байж болдог.
4. Цахим бооцоот/мөрийтэй/ тоглоом: Интернет, утас, телевиз, радио болон бусад технологийг ашиглан мөрийтэй тоглоомд оролцохыг хэлнэ гэж тодорхойлсон байна.

Дэлхий даяар цахим мөрийтэй тоглоомын зах зээл маш хурдацтай өсөж байгаа бөгөөд 2021 онд ойролцоогоор 58 тэрбум ам.долларын эргэлттэй байсан бөгөөд 2022–2030 оны хооронд жилийн нийлмэл

өсөлтийн хурд (CAGR) ойролцоогоор 11.8%–иар 2030 он гэхэд 182.21 тэрбум доллар болж өсөх төлөвтэй байна гэж судалгаанд дурджээ⁶. Технологийн дэвшлийн нөлөөгөөр гар утасны програмуудаар дамжуулан цахим платформуудыг ашиглан цахим тоглоом тоглох боломжтой болсноор энэ зах зээл хурдацтай тэлж байна.

Цахим мөрийтэй тоглоом гэдэгт интернэтэд суурилсан буюу компьютер, гар утас, таб гэх мэт ямар ч төхөөрөмжийн интернэт холболт ашиглан тоглож болох мөрийтэй тоглоомуудыг хамруулж ойлгож болно. Цахим мөрийтэй тоглоомын тоглогчид нь дансандаа мөнгө байршуулж, байршуулсан мөнгөө ашиглан тоглох болон бооцоо тавих замаар оролцдог. Сүүлийн жилүүдэд цахим мөрийтэй тоглоомын салбар нь блокчейн технологийг нэвтрүүлж, криптовалют ашиглан мөрийтэй тоглоомын гүйлгээ хийх явдал газар аваад байна. Криптовалютын гүйлгээнд тавигдах хязгаарлалт багатай, гүйлгээ хийхэд хурдан, хялбар байгаа зэрэг шинж чанараас хамаарч хэрэглэгчид цахим мөрийтэй тоглоомын төлбөр тооцоог криптовалютаар хийх хандлага их болж байна.

III. ОРОЛЦОГЧ ТАЛУУД БА ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭ

Data40.com байгууллагаас хийсэн судалгаагаар (www.data40.com) уламжлалт мөрийтэй тоглоомын хувьд нийт 231 улсын 66.7 хувь нь хуулийн зохицуулалттай, 20.3


хувь нь хуулиар хориглодог, 9.1 хувь нь хэсэгчилсэн зохицуулалттай, 2.2 хувь нь энэ талаар ямар нэг зохицуулалтгүй бол 1.7 хувь нь зөвхөн Засгийн газар энэ төрлийн үйл

⁶ <https://www.fnfresearch.com/online-gambling-and-betting-market>


ажиллагааг зохион байгуулдаг байна. Харин цахим мөрийтэй тоглоомын хувьд нийт 231 улсын 56.7 хувь нь хуулийн зохицуулалттай, 26.4 хувь нь хуулиар хориглодог, 5.6 хувь нь

хэсэгчилсэн зохицуулалттай, 10 хувь нь энэ талаар ямар нэг зохицуулалтгүй бол 1.3 хувь нь зөвхөн Засгийн газар энэ төрлийн үйл ажиллагааг зохион байгуулдаг байна.

Зураг 1. Цахим бооцоот тоглоом (online)-ын зохицуулалтын ерөнхий байдал, улс орноор




Зураг 2. Уламжлалт мөрийтэй тоглоом (offline)-ын зохицуулалтын ерөнхий байдал, улс орноор



Цахим болон уламжлалт мөрийтэй тоглоомын зохицуулалтыг бүс нутгийн байдлаар авч үзвэл дараах байдалтай байна.

Зураг 3. Латин Америкийн бүс нутгийн мөрийтэй тоглоомын зохицуулалт

Латин Америкийн бүс нутаг (LATAM)




Латин Америкийн бүс нутгийн 37 улс орнуудаас цахим мөрийтэй тоглоомыг хуулиар зөвшөөрсөн 19, хууль бус 8, хэсэгчилсэн зохицуулалттай⁷ 1,

зохицуулалтгүй 9 улс байгаа бол мөрийтэй тоглоомын газар ажиллуулахыг хүлээн зөвшөөрсөн 31, хууль бус 3, хэсэгчилсэн 2, зохицуулалтгүй 1 улс байна.

Зураг 4. Европ, Ойрх Дорнод, Африк бүс нутгийн мөрийтэй тоглоомын зохицуулалт

Европ, Ойрхи Дорнод, Африк бүс нутаг




Европ, Ойрх Дорнод, Африк бүс нутгийн 146 улс орнуудаас цахим мөрийтэй тоглоомыг хуулиар зөвшөөрсөн 104, хууль

бус 32, хэсэгчилсэн зохицуулалттай 5, зохицуулалтгүй 2, зөвхөн засгийн газар нь зохицуулдаг 3 улс байгаа бол мөрийтэй

⁷ Мөрийтэй тоглоомын төрлөөс хамаарч зарим тоглоомыг хүлээн зөвшөөрдөг, зарим тоглоомыг хориглодог.

тоглоомын газар ажиллуулахыг хүлээн зөвшөөрсөн 107, хууль бус 26, хэсэгчилсэн 10, зөвхөн засгийн газар нь зохицуулдаг 3 улс байна.

Зураг 5. Ази–Номхон далайн бүс нутгийн мөрийтэй тоглоомын зохицуулалт



Ази–Номхон далайн бүс нутгийн 46 улс орнуудаас цахим мөрийтэй тоглоомыг хуулиар зөвшөөрсөн 7, хууль бус 21, хэсэгчилсэн зохицуулалттай 6, зохицуулалтгүй 13 улс байгаа бол мөрийтэй тоглоомын газар ажиллуулахыг хүлээн зөвшөөрсөн 15, хууль бус 18, хэсэгчилсэн 8, зохицуулалтгүй 4, зөвхөн засгийн газар нь зохицуулдаг 1 улс байна. **Хойд–Америкийн** бүс нутгийн 2 улс орнуудаас цахим мөрийтэй тоглоомыг хуулиар зөвшөөрсөн 1, хэсэгчилсэн зохицуулалттай

1 улс байгаа бол мөрийтэй тоглоомын газар ажиллуулахыг хүлээн зөвшөөрсөн 1, хэсэгчилсэн зохицуулалттай 1 улс байна.

Европ, Ойрх Дорнод, Африк бүс нутаг, Хойд америк, Латин Америкийн бүсийн орнуудын хувьд зохицуулалттай зах зээл 50–80 хувийг эзэлж байгаа бол Ази–Номхон далайн бүс нутагт 39–45 хувь нь зөвшөөрдөггүй болон хэсэгчилсэн зохицуулалттай улс орнууд 13–17 хувийг тус тус эзэлж байна. Зах зээлийн үйл ажиллагаанд дараах төрлийн оролцогч талууд хамрагдаж байна.

Хүснэгт 1. Оролцогч талууд ба үүрэг

Байгууллагын төрөл	Үүрэг	Байгууллагын жишээ
<p>Төрийн эрх бүхий байгууллагууд</p>	<p>Бооцоот тоглоомын үйл ажиллагааг хянан шалгах, зөвшөөрөл олгох, хууль, дүрэм журам болон стандартын хэрэгжилтийг хангуулах.</p>	<p>Англи улс UK Gambling Commission Парламентын харьяа байгууллага</p>
		<p>Герман Gemeinsame Glücksspielbehörde der Länder (GGL) 16 муж улсуудын хамтарсан байгууллага– Мужийн захиргаанд ажлаа тайлагнадаг.</p>
		<p>Япон улс Japan Casino Regulatory Commission (JCRC)– Засгийн газрын ажлын албанд харьяалагддаг. National Public Safety Commission (NPSC), Ministry of Economy, Trade, and Industry (METI), National Gambling Control Commission, NGCC) Салбарын яамдад харьяалагдана.</p>
		<p>БНСУ Korea Communications Commission (KCC)– Засгийн газрын салбарын яамдад харьяалагддаг. National Police Agency (NPA), Financial Intelligence Unit (FIU)</p>
		<p>Сингапур Gambling Regulatory Authority Засгийн газарт харьяалагддаг–Дотоод хэргийн яам</p>
<p>ОХУ Холбооны татварын алба (FTS): Бооцооны компаниудад лиценз олгох, тэдний үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй. Засгийн газрын харьяа байгууллага. Роскомнадзор: Хориотой мөрийтэй тоглоомын сайтуудад хандах хандалтыг хянаж, хаадаг. ОХУ–ын Спортын яам: Спортын бооцооны зохицуулалтын тогтолцоог боловсруулахад оролцдог.</p>		

Мэргэжлийн холбоо	Олон улсын зохицуулалтыг хянах, харилцан зөвлөмж, стандарт, эрсдэлийн үнэлгээ боловсруулах, гишүүн орнуудын хоорондын хамтын ажиллагааг дэмжих.	European Gaming and Betting Association (EGBA), International Association of Gaming Regulators (IAGR)
Бооцоот тоглоомын оператор/агентууд	Төрийн байгууллагаас авсан зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг. Уламжлалт болон онлайн тоглоомуудыг зохион байгуулах, үйл ажиллагааг явуулах, хэрэглэгчийн бүртгэл, төлбөрийн гүйлгээ, болон тоглоомын аюулгүй байдлыг хангах. Хэрэглэгчдийн эрх ашиг, тоглоомын шударга байдлыг хангах, хууль зөрчлөөс урьдчилан сэргийлэх.	Олон улсын болон дотоодын хувийн компаниуд (Singapore Pools)
Хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлийн оролцогч	Сайн дурын үндсэн дээр байгуулагддаг, хэрэглэгчдийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах, шударга өрсөлдөөн, мэдээллийн ил тод байдлыг хангах, зөвлөмж болон тусламж үйлчилгээ үзүүлэх.	GamCare, Gambling Therapy
Төлбөрийн системийн оролцогч	Бооцоот тоглоомын үйл ажиллагааг хөнгөвчилдөг, төлбөрийн гүйлгээг баталгаажуулж, хамгаалалтыг хангах, цахим төлбөрийн технологийн системийг хөгжүүлэх.	Зээлийн карт, крипто төгрөгийн платформууд (жишээ нь: Apple Pay, крипто системүүд)

Эх сурвалж: Судлаачдын боловсруулалт

Дээрх мэдээллээс харахад бооцоот тоглоомын зах зээлийн оролцогчид дараах үндсэн чиглэлээр зохицуулалт хийдэг байна. Үүнд:

- Тусгай зөвшөөрөл олголт ба хяналт
- Татвар ба санхүүгийн зохицуулалт
- Хариуцлагатай тоглоомын бодлого буюу насанд хүрээгүй хүмүүсийг

- хамгаалах арга хэмжээ, донтохоос сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэх
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
- Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах/ өгөгдөл хамгаалах
- Маркетинг, зар сурталчилгаа

- Олон улсын хамтын ажиллагаа – Гадаадын операторуудтай хэрхэн харьцах (зарим улсад зөвхөн дотоодын оператор ажиллах эрхтэй). Олон улсын мөрийтэй тоглоомын зохицуулалтын байгууллагуудтай хамтран ажиллах зэрэг болно.
- Судалгаанд авч үзсэн 6 улсын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгогч байгууллагуудын 4 нь засгийн газар, салбарын яамд (1 нь Засгийн газрын ажлын албанд), 1 нь парламент, 1 нь мужийн захиргааны харьяанд үйл ажиллагаа явуулж байна.

IV. УЛС ОРНУУДЫН ХУУЛЬ, ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Бооцоот тоглоомын үйл ажиллагааг хориглосон улс орнуудын зохицуулалтыг зөвшөөрсөн болон хэсэгчлэн зөвшөөрсөн, доорх хүснэгтэд нэгтгэв.

Хүснэгт 2. Үйл ажиллагааг хуулиар бүрэн болон хэсэгчлэн зөвшөөрсөн улс орнуудын зохицуулалт

№	Улс	Бооцоот тоглоомын зохицуулалт /уламжлалт, цахим/	Зохицуулалт
1	Их Британи	<ul style="list-style-type: none"> - Gaming Act 1968 - Gambling Act 2005 - Gambling (Licensing and Advertising) Act 2014 	<ul style="list-style-type: none"> - Мөрийтэй тоглоомын төрлийг багасгах, зохион байгуулалттай гэмт хэргээс сэргийлэх зорилготой. - Мөрийтэй тоглоомын зөвшөөрөл олгох, татвар төлөх шаардлагыг тогтоосон. - Сурталчилгааны хяналттай бөгөөд зөвхөн зөвшөөрөлтэй байгууллагууд мөрийтэй тоглоом сурталчлах эрхтэй. - Онлайн мөрийтэй тоглоомын нийт ашигт 21 хувийн татвар ногдуулдаг.
2	Сингапур	<ul style="list-style-type: none"> - Betting Act 1960 - Common Gaming House Act 1961 - Private Lotteries Act 2011 - Remote Gambling Act 2014 	<ul style="list-style-type: none"> - Мөрийтэй тоглоомыг зохицуулах, тоглогчдын аюулгүй байдлыг хангах зорилготой. - Лотоны хяналт ба татварын зохицуулалттай. - Нийтийн мөрийтэй тоглоомын газрууд, бооцооны газруудыг хянадаг. - Онлайн мөрийтэй тоглоомд тодорхой хязгаарлалт тавьдаг.

3	Солонгос Улс	Эрүүгийн хууль article 246, 247, 248 Үндэсний спортыг дэмжих тухай хууль 48 дугаар зүйл Сугалааны тухай хууль Моторт болон мото уралдааны тухай хууль Бухын уламжлалт тэмцээний тухай хууль	<ul style="list-style-type: none"> - Цахим мөрийтэй тоглоомыг хориглодог. - Уламжлалт мөрийтэй тоглоомтой холбоотой бооцооны үйл ажиллагааг зохицуулдаг. - Хүлээн зөвшөөрдөг бооцоот тоглоом тус бүр хуультай: - Сугалааны тасалбар олгох, удирдах, худалдах үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагаа - Моторт завь болон моторт уралдааны үйл ажиллагаа - Уламжлалт бухын барилдааныг сэргээх, бухын уралдаантай холбоотой үйл ажиллагаа
4	Герман улс	Герман Улсын мөрийтэй тоглоомын тухай хууль (2021)	<ul style="list-style-type: none"> - Спортоос бусад зүйлд бооцоо тавихыг хориглоно. /хөл бөмбөг, гандбол, теннис, автомашины спорт, шайбтай хоккей, дартс, цана, биатлон, боб спорт, кёрлинг, тэшүүр, луж зэрэг спортын бооцооны зөвшөөрөгдөх жагсаалт байдаг/ - Улс хоорондын гэрээнд нэг тоглогчийн дагаж мөрдөх сарын 1000 еврогийн хэмжээтэй оператор хоорондын хадгаламжийн дээд хязгаарыг тусгасан. - Зар сурталчилгааны арга хэмжээ нь насанд хүрээгүй хүүхэд болон бусад эмзэг бүлгийн зорилтот бүлэгт чиглэгдэж, төөрөгдүүлсэн байх ёсгүй. - Нийгмийн хариуцлагын хүрээнд мөрийтэй тоглоомд донтох, гэмт хэргийн шинжтэй үйлдлээс урьдчилан сэргийлэх, тоглогчдыг зохицуулалттай зах зээл рүү, хар захаас холдуулах, насанд хүрээгүй хүүхдүүдийг хамгаалах, спортын бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй - Спортын бооцоо, виртуал тоглоом, онлайн покерын бүх бооцоонд 5.3 хувийн татвар ногдуулдаг бөгөөд тоглогчдын нийт бооцоонд үндэслэн тооцдог.
	ОХУ	244–ФЗ Холбооны хуулиар “Мөрийтэй тоглоомын зохион байгуулалт, явуулах төрийн зохицуулалтын тухай, 2006	<p>Цахим мөрийтэй тоглоомын салбарт зохицуулалт нэлээд хатуу зохицуулалттай байдаг. 1xBet нь олон улсын бооцоо тавьдаг компани бөгөөд Орос улсад үйл ажиллагаа явуулдаг. Тус улсын хууль тогтоомжийн дагуу цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагааг зохицуулахдаа дараах алхмуудыг хэрэгжүүлдэг.</p> <ul style="list-style-type: none"> - Орос улсад цахим мөрийтэй тоглоомын орлогоос 13 хувийн татвар ногдуулдаг. Энэ нь хувь хүний орлогын албан татвар бөгөөд тоглогчийн хожлоос авдаг татвар юм. - Хэрэв тоглогч Орос улсын иргэн биш бол татварын хувь хэмжээ 30 байж болно. - 1xBet зэрэг цахим мөрийтэй тоглоомын компаниуд нь Орос улсад үйл ажиллагаа явуулж байгаа орлогоосоо 20 хувь орчим корпорацийн татвар төлдөг. - Мөн тэдгээр компаниуд нь бусад хууль ёсны шаардлагыг хангаж, лицензийн төлбөр, тусгай шимтгэл төлдөг.

Япон	<ul style="list-style-type: none"> - Эрүүгийн хууль article 185,186 - Мөрийтэй уралдааны тухай хууль 	<p>Цахим бооцоот тоглоомыг бүхэлд нь хориглоно. Японд мөрийтэй тоглоомын ихэнх хэлбэрийг Эрүүгийн хуулийн 23 дугаар бүлэгт хориглосон байдаг ба морин уралдаан, моторт спорт зэрэг үйл ажиллагааг Мөрийтэй уралдааны тухай хуулиар зохицуулдаг байна.</p> <ul style="list-style-type: none"> - Пачинко— Аркад маягийн тоглоом бөгөөд албан ёсоор мөрийтэй тоглоом биш гэж ангилдаг. (Гэсэн ч практикт бооцоот тоглоомын системтэй.) - Морин уралдаан – Засгийн газрын зөвшөөрөлтэй, бооцоо тавих боломжтой. - Авто уралдаан – Усан онгоц, дугуй, мотоциклийн уралдаанд бооцоо тавих боломжтой. - Сугалаа – Улсын хяналттай сугалааны тоглоомуудыг зөвшөөрдөг. - Спортын бооцоо— Хөл бөмбөгийн бооцоот тоглоомыг зөвшөөрдөг. - Казино – 2018 онд хуулиар зөвшөөрөгдсөн ч зөвхөн тусгай лицензтэй газруудад ажиллах боломжтой. <p>Эрүүгийн хууль—Мөрийтэй тоглоом тоглосон этгээдэд 500,000 иен хүртэл (\$3,300) торгууль эсвэл 3 сар хүртэл хорих ял оноож болно. Их хэмжээний бооцоотой тоглоомын хувьд 3 жил хүртэл хорих ял ногдуулна.</p> <ul style="list-style-type: none"> - Хууль бус мөрийтэй тоглоомын газар ажиллуулах, зохион байгуулсан хүн 5 жил хүртэл хорих ял, өндөр торгууль төлнө.
------	--	--

Эх сурвалж: Судлаачдын боловсруулалт болон The Comparative of Regulations About Online Gambling Between Indonesia, Malaysia, Singapore, And United Kingdom

Хүснэгт 3. Бооцоот тоглоомын үйл ажиллагааг хориглосон улсууд

№	Улс	Бооцоот тоглоомын зохицуулалт /уламжлалт, цахим/	Зохицуулалт
1	Хятад улс	<ul style="list-style-type: none"> - БНХАУ–ын Эрүүгийн хууль 1997 - Олон нийтийн аюулгүй байдлын удирдлагын шийтгэлийн тухай хууль 2006 - Хятадын Кибер аюулгүй байдлын тухай хууль 2017 	<ul style="list-style-type: none"> - Мөрийтэй тоглоомыг эх газрын Хятадад хатуу хоригло– дог, онлайн болон оффлайн бүх хэлбэрийг зөвшөөрдөггүй. - Зөвхөн төрийн зохицуулалттай лото (China Sports Lottery & China Welfare Lottery) нь хууль ёсны мөрийтэй тоглоомын цорын ганц хэлбэр юм. - Мөрийтэй тоглоом зохион байгуулсан хувь хүмүүс эрүүгийн хариуцлага хүлээх бөгөөд шоронд хорих ялтай. - Онлайн мөрийтэй тоглоомын платформууд болон мөрийтэй тоглоомтой холбоотой төлбөрийн системүүдийг хориглож, хаадаг. - Макао бол Хятадын мөрийтэй тоглоом хууль ёсны цорын ганц бүс бөгөөд тусгай зохицуулалттайгаар казино ажиллуулахыг зөвшөөрдөг.

2	Индонез	<ul style="list-style-type: none"> - Pasal 303, 303 bis KUHP - UU No. 7 Tahun 1974 (Мөрийтэй тоглоомын хяналт) - PP No. 9 Tahun 1981 (Мөрийтэй тоглоомын хяналт хэрэгжүүлэх тухай) - Pasal 27 ayat (2), Pasal 45 ayat (2) UU ITE 	<ul style="list-style-type: none"> - UU-ITE-ийн 27-р зүйлийн 2-р хэсэг ба Эрүүгийн хуулийн хооронд уялдаа холбоо бий. - Мөрийтэй тоглоомыг ёс суртахуун, нийгмийн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл гэж үздэг. - Мөрийтэй тоглоомын зөрчил гаргасан хүмүүст хорих ял оноодог. - Мөрийтэй тоглоомын контент агуулсан цахим мэдээллийг түгээхийг хориглодог.
---	---------	--	---

Эх сурвалж: Судлаачдын боловсруулалт болон The Comparative of Regulations About Online Gambling Between Indonesia, Malaysia, Singapore, And United Kingdom¹

Монгол Улсын хууль эрх зүйн орчин

Монгол Улсын Их Хурал 1998 онд Казиногийн тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2003 оны 155 дугаар тушаалаар “Төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа явуулах журам”-ыг баталж байсан бөгөөд хүчингүй болгосон байна (www.legalinfo.mn). Мөн 2022 онд Засгийн газраас Казиногийн тухай хуулийн төсөл, Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төсөл, Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд 2023 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж, УИХ-ын нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтсон байна. Эдгээр хуулийн төслүүдээр Монгол Улсын нутаг дэвсгэрт мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэх нийтлэг зохицуулалтыг бий болгож, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, оролцогчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулна гэж тодорхойлсон ажээ (www.parliament.mn, 2023).

Одоогийн байдлаар Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн актуудад тус зах зээлийн талаар дараах зохицуулалтууд байна. Үүнд:

1. *Зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр бүлгийн 11.4-д* “төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгохоор зохицуулсан бол 6.5-д эд мөнгөний хонжворт сугалаа гаргах тусгай зөвшөөрлийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгохоор зохицуулсан.
2. *Эрүүгийн хуулийн 20 дугаар бүлгийн 20.17-д* “олон нийтийн газар эсвэл мэдээллийн технологи ашиглан ашиг олох зорилгоор мөрийтэй тоглоом зохион байгуулсан бол 450–14,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсвэл 240–720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсвэл 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх, мөн хуулиар хориглосон мөрийтэй тоглоомын газар байгуулсан,

эсвэл ажиллуулсан тохиолдолд 5,400–27,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсвэл 1–5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан.

3. *Зөрчлийн тухай хуулийн 5 дугаар бүлгийн 5.7–д* “олон нийтийн газар ашиг олох зорилгоор мөрийтэй тоглоом тоглосон бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заасан.
4. *Иргэний хуулийн 486 дугаар зүйлийн 486.1–д* Тоглоом болон мөрий нь шаардах эрхийг бий болгохгүй, 486.2–т Тоглох, мөрий тавихад зориулан олгосон зээл, урьдчилгаа, түүнчлэн мөрийний шинжийг агуулсан хөрөнгө нийлүүлэх

тухай биржийн болон түүнтэй төстэй хэлцэлд энэ хуулийн 486.1–д заасан журам нэгэн адил үйлчилнэ, 486.3.–т Хуулиар хориглосноос бусад тоглоом болон мөрийний дагуу төлсөн мөнгө, шилжүүлсэн хөрөнгө, бусад зүйлийг эргүүлэн шаардаж болохгүй, 486.4.–т Хонжворт сугалаа, түүнтэй төсөөтэй бусад тоглоом нь эдгээрийг төрөөс зөвшөөрсөн тохиолдолд л шаардах эрхийг бий болгоно гэж заасан.

5. *Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд* Төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны хонжворын орлогод 40 хувиар татвар ногдуулах зохицуулалттай.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Судалгаанаас дүгнэхэд дэлхийн хэмжээнд бооцоот тоглоомын зах зээл өргөн цар хүрээтэй ч бүх улсад хууль ёсны гэж тооцогддоггүй бөгөөд бооцоот тоглоомыг улс орнууд төрөл бүрээр ангилж, зөвшөөрч, хэсэгчлэн зөвшөөрч, хориглож байна. Нийт 231 орноос 66.7 хувь нь хуулиар хүлээн зөвшөөрсөн байна. Цөөн улс орны хувьд ямар нэг зохицуулалтгүй бол зөвхөн Засгийн газар энэхүү үйл ажиллагааг зохион байгуулах эрхтэй улс орон ч байна. Мөн БНХАУ, Индонез зэрэг улс энэхүү үйл ажиллагааг хуулиар хориглосон байна.

Тухайн улс дахь зохицуулалтын онцлогийн дагуу зөвшөөрөл олголт, хяналт, татвар болон хэрэглэгчийг хамгаалах арга хэмжээ зэргээс шалтгаалан олон янзын загварууд бий болж байна. Зах зээлд оролцогчид нь төрийн зохицуулагч байгууллага, мэргэжлийн холбоод, бооцоот тоглоомын оператор, хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллага, төлбөрийн системийн оролцогчид байгаа бөгөөд эдгээр нь тус тусын үүрэг оролцоотой бөгөөд төрийн зохицуулагч байгууллага нь зөвшөөрөл олгох, хянах, мэргэжлийн холбоод нь зөвлөмж, стандарт, эрсдэлийн үнэлгээ, олон улсын хамтын ажиллагааг хангах, операторууд нь зөвшөөрлийн үндсэн дээр ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлийн сайн дурын байгууллагууд, төлбөрийн системийн оролцогчид нь гүйлгээг баталгаажуулан гүйцэтгэдэг байна.

Хууль ёсны зохицуулалттай улсуудад ихэвчлэн мөрийтэй тоглоомыг хянах, зохицуулах тусгайлсан байгууллагатай байна. Жишээлбэл: Их Британид Мөрийтэй тоглоомын хороо (Gambling Commission), Солонгос Улсад Үндэсний мөрийтэй тоглоомын хяналтын хороо (National Gambling Control Commission, NGCC), Сингапур Улс Мөрийтэй тоглоомын үйлчилгээ үзүүлэгч байгууллага (Gambling Regulatory Authority) гэх зэрэг байгууллагууд байна. Судалгаанд авч үзсэн 6 улсын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгогч байгууллагуудын 4 нь засгийн газар, салбарын яамд (1 нь засгийн газрын ажлын албанд), 1 нь парламент, 1 нь мужийн захиргааны харьяанд үйл ажиллагаа явуулж байна.

Үйл ажиллагааг хуулиар зөвшөөрдөг 6 улс, хориглодог 2 улсын зохицуулалтыг судалсан бөгөөд 3 улсын хувьд зах зээлийг зохицуулах 1 хуультай бол 3 улс нь бооцоот тоглоомын ерөнхий төрөл тус бүрээр хууль баталсан бол ихэнх улс зөрчлийг шийтгэх үйл ажиллагааг Эрүүгийн хуульд тусгасан байна. Тухайлбал, Япон улсад Мөрийтэй тоглоом тоглосон этгээдэд 500,000 иен хүртэл (\$3,300) торгууль эсвэл 3 сар хүртэл хорих ял оноож болно. Их хэмжээний бооцоотой тоглоомын хувьд 3 жил хүртэл хорих ял ногдуулна. Хууль бус мөрийтэй тоглоомын газар ажиллуулах, зохион байгуулсан хүн 5 жил хүртэл хорих ял, өндөр торгууль төлнө. Татварын зохицуулалтын хувьд ОХУ-д

үйл ажиллагаа явуулсан операторын хувьд корпорацын 20 хувийн татвар, үйл ажиллагаанаас орлого олсон тус улсын иргэн орлогын 13 хувь, тус улсын иргэн биш бол 20 хувийг төлдөг бол, Герман улсад бүх төрлийн бооцоонд 5.3 хувийн татвар, Их Британид нийт ашгийн 21 хувийг татварт төлдөг байна.

Мөн Герман улсад нэг тоглогчийн сарын оролцооны дүн 1000 евро байхаар оператор хоорондын хадгаламжийн дээд хязгаарыг тогтоосон.

Монгол Улсын хувьд 1998 онд батлагдсан Казиногийн тухай хууль болон 2003 онд батлагдсан төлбөрт таавар, бооцоот тоглоомын журам хүчингүй болсон бөгөөд Казиногийн тухай хуулийн төсөл, Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төсөл, Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна. Одоогийн хүчин төгөлдөр хууль, эрх зүйн актууд нь мөрийтэй тоглоомын үйл

ажиллагаанд зөвшөөрөл олгох, зохицуулах, хяналт тавих, мөн татвар, ял шийтгэл зэрэг зохицуулалтуудыг агуулсан шинжтэй байна.

Судалгааны үр дүнд суурилан дараах саналыг боловсрууллаа. Үүнд:

- Зах зээлийг зохицуулсан тусгайлсан хууль батлах /тоглоомын уламжлалт болон онлайн хэлбэрийг хамруулсан/;
- Засгийн газар /Хууль зүйн яам, Спортын чиглэлийн яам/-ын харьяа агентлаг зөвшөөрөл олгож, хянах;
- Зөрчил үүссэн тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ;
- Цахим хуудсыг хаах;
- Төлбөрийн системүүдийг хязгаарлах
- Зар сурталчилгаа хийхийг хязгаарлах
- Татварыг оролцогч талын сонирхлоос хамааруулан ашиг, бооцоо, орлогын хэмжээнд тохируулан ялгамжтай тогтоох зэрэг болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Parliament.mn. (n.d.). Монгол Улсын Их Хурлын албан ёсны вэб сайт. <https://www.parliament.mn>
- Legalinfo.mn. (n.d.). Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн портал. <https://www.legalinfo.mn>
- Data40.com. (n.d.). Data portal and statistics of Mongolia. <https://www.data40.com>
- A Study on Legal Improvement Measures for Corporate ESG Institutionalization – Focusing on Corporate Social Responsibility. (n.d.). DBpia. <https://www.dbpia.co.kr/Journal/articleDetail?nodeId=NODE11745684>
- Aidah, K. N., & Pratama, B. (2022). The comparative of regulations about online gambling between Indonesia, Malaysia, Singapore, and United Kingdom. IEOM Society. <https://ieomsociety.org/proceedings/2022malaysia/362.pdf>
- Chernenko, M. (2024). Global gambling and iGaming regulations: A complete list. Data40. <https://data40.com/articles/global-gambling-and-igaming-regulations-a-complete-list-2024/>
- Data40. (2025). Financial market datasets and analytics. Retrieved from <https://data40.com/financial-market-data>
- Enforcement Rules of the Motorcycle Racing and Motorboat Racing Act. (n.d.). <https://law.go.kr/LSW/lsSc.do?section=&menuId=1&subMenuId=15&tabMenuId=81&eventGubun=060101&query=%EA%B2%BD%EB%A5%9C%EA%B2%BD%EC%A0%95%EB%B2%95>
- Fiedler, I. (2018). Regulation of online gambling. *Economics and Business Letters*, 7(4), 162–168. <https://doi.org/10.17811/ebl.7.4.2018.162-168>
- Gambling Act 2005, c.19. (2005). <https://www.legislation.gov.uk/ukpga/2005/19/contents>
- Gambling harm prevention and harm reduction in online environments: A call for action. (n.d.). *Harm Reduction Journal*. <https://harmreductionjournal.biomedcentral.com/articles/10.1186/s12954-023-00828-4>
- Gangwon Special Self-Governing Province Investment Organization Establishment and Support Ordinance for the Creation of Legoland Korea. (n.d.). <https://law.go.kr/ordinSc.do?menuId=3&subMenuId=27&tabMenuId=139&query=%EA%B0%95%EC%9B%90%EB%9E%9C%EB%93%9C>
- H2 Gambling Capital. (n.d.). Gambling capital. <https://h2gc.com/>

- Hornle, J. (n.d.). Prevent online gambling harm through better regulation. Queen Mary University of London. <https://www.qmul.ac.uk/law/research/featured-research/preventing-online-gambling-harm-through-regulation>
- Korean Communications Commission. (n.d.). <https://www.kcc.go.kr/user/ehpMain.do>
- Korean Criminal Law: Chapter 23. (2024). <https://law.go.kr/LSW/eng/engMain.do>
- Korean Financial Intelligence Unit. (n.d.). <https://www.kofiu.go.kr/eng/main.do>
- Korean Problem Gambling Agency. (n.d.). <https://www.kcgp.or.kr/portal/main/main.do>
- Korea Racing Authority Act. (n.d.). <https://law.go.kr/lsSc.do?menuId=1&subMenuId=15&tabMenuId=81&query=%EA%B2%BD%EB%A7%88>
- Law on traditional bull fighting competitions. (n.d.). <https://law.go.kr/LSW//lsSc.do?section=&menuId=1&subMenuId=15&tabMenuId=81&eventGubun=060101&query=%EC%A0%84%ED%86%B5+%EC%86%8C%EC%8B%B8%EC%9B%80%EA%B2%BD%EA%B8%B0%EC%97%90+%EA%B4%80%ED%95%9C+%EB%B2%95%EB%A5%A0>
- Legislation on bookmakers: Working with the Federal Tax Service and regulation of online gambling in Russia (on the example of TSUPIS). (n.d.). <https://pksberinvest.ru/zakonodatelstvo-o-bukmekerskih-kontorah-rabota-s-fns-i-regulirovanie-onlayn-gemblinga-v-rossii-na-primere-tsupis/>
- Lottery and Lottery Fund Act. (n.d.). 국가법령정보센터. <https://law.go.kr/LSW//lsSc.do?section=&menuId=1&subMenuId=15&tabMenuId=81&eventGubun=060101&query=%EB%B3%B5%EA%B6%8C+%EB%B0%8F+%EB%B3%B5%EA%B6%8C%EA%B8%B0%EA%B8%88%EB%B2%95>
- Marionneau, V. (2020). Legislation on bookmakers: Working with the Federal Tax Service and regulation of online gambling in Russia (on the example of TSUPIS). *International Journal of Russian Studies*, 9(2). https://www.ijors.net/issue9_2_2020/pdf/___www.ijors.net_issue9_2_2020_article_2_marionneau.pdf
- Statista Research Department. (2024). Sports betting worldwide – statistics & facts. Statista. <https://www.statista.com/topics/1740/sports-betting/>
- Status of illegal sports betting and applicable law. (n.d.). <https://www.moleg.go.kr/index.es?sid=a1>
- Федеральный закон № 244–ФЗ «О государственном регулировании деятельности по организации и проведению азартных игр и о внесении изменений в некоторые

законодательные акты Российской Федерации» [Federal Law No. 244–FZ on state regulation of gambling]. (n.d.). https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_64924/d6fb3580fbd6ef3e662688c02af241894aa7f3a6/